



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/Н10

Хэрлэн сум

Ногоон байгууламж, хамгаалалтын  
зурвас байгуулахад зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны аравдугаар хуралдааны “Гучин сая мод” хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 07 дугаар тогтоол, 2023 оны хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, хүүхэд залуусыг мод тарьж ургуулах, арчлах, хамгаалах ажилд сургах, экологийн боловсрол олгох хүрээнд Цэнхэрмандал сумын Нугаар баг дахь “Хүүхдийн хөдөлмөр зуслан”-д ногоон байгууламж, хамгаалалтын зурвас байгуулахад зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 07 дугаар сарын 21-ны  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Жимсний мод	ш	250	12,000	3,000,000
	<b>Нийт дүн</b>				<b>3,000,000</b>